



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/Н5

Бор-Өндөр сум

АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэний тухай хуулийн 351 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уурхайчин 4 дүгээр багийн усан сан засварлах ажлыг хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Ч.Саруулмөнх

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Ж.Бүжингоо

Бор-Өндөр "Хот тохижилт" ОНТҮГ-ын нярав

Гишүүд:

Д.Халиунаа

Уурхайчин 4 дүгээр багийн зохион байгуулагч

Б.Бадамцэцэг

Бор-Өндөр "Хот тохижилт" ОНТҮГ-ын орлого бүрдүүлэгч

Иргэний төлөөлөл:

Г.Цэрэннадмид

Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн Харуул

2. Уурхайчин 4 дүгээр багийн усан сан засварлах ажлыг шалган, хүлээн авах зохих хууль, журмын дагуу баримт материалыг бүрдүүлэн ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Ч.Саруулмөнх/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч дарга (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ